



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Иргэн, хуулийн этгээдээс улс төрийн нам, нэр дэвшигчдэд
нийт 271.2 сая төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна.

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/12-ШТА-НА-СБА

Баруун-Урт 2024 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа
Утас: 70518396, Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа
Утас: 70512123, Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор С.Ариунбаяр
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунзул
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn

Аудитор: А.Мөнхцэцэг
Утас: 70512127, Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/84

Баруун-Урт сум

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушвалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх"-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Нам, нэр дэвшигчийн зардлын тайлан, мөнгөн хандивын талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулахыг ахлах аудитор (С.Ариунбаяр)-д үүрэг болгосугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 20, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор тус тус Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Ариунжаргал), Татварын газрын дарга (Д.Мөнхбаяр) нарт хариуцуулсугай.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (С.Ариунбаяр), аудитор (А.Мөнхцэцэг), аудитор (Б.Ариунзул) нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү тушвалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

D:\Бичиг хэрэг\1. А тушаал 2024.docx

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
1.1 Улс төрийн нам, нэр дэвшигчдэд иргэн, хуулийн этгээдээс 271.2 сая төгрөгийн мөнгөн хандив өгчээ. Error! Bookmark not defined.	
БҮЛЭГ2: Нам, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансанд төвлөрсөн хөрөнгийг хуульд нийцүүлэн зарцуулж, зардлын тайлангаа хараат бус аудитын компаниар баталгаажуулсан байна.....	6
2.1 Нэр дэвшигчдийн 97.8 хувь нь сонгуулийн зардлын тайланг хуулийн хугацаанд хүргүүлж дүгнэлт гаргуулжээ.....	6
2.2 Нам, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулсан зардал нийцсэн байна.....	7
ДҮГНЭЛТ:.....	9

Товчилсон үгийн тайлбар

АН	Ардчилсан нам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИХН	Иргэний хөдөлгөөний нам
МАН	Монгол ардын нам
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Улс төрийн намд хандив өгсөн иргэн хуулийн этгээдийн судалгаа	3
2	Нэр дэвшигчид иргэн хуулийн этгээдээс өгсөн хандивын судалгаа	4-5
3	Улс төрийн намын сонгуульд зарцуулсан мөнгөн хөрөнгө	7
4	Сумын ИТХ-д нэр дэвшигчийн зарцуулсан зардлын задаргаа	8

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалт, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны 08 дугаар тогтоол, Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.
	Аудитын зорилт
	Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн сурталчилгаанд зарцуулсан зардал Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нийцсэн эсэхэд дүгнэлт гаргаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын тайлан, дүгнэлтийн

хүрээнд гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцсон 10 нэр дэвшигч зардлын дансны мэдээлэл ирүүлээгүй, 51 нэр дэвшигч хуульд нийцээгүй мөнгөн хандив зарцуулсан байна

Иргэн, хуулийн этгээдээс улс төрийн нам, нэр дэвшигчдэд нийт 271.2 сая төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна

1.1.1 Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд 4 намын 610 нэр дэвшигч, 1 бие даан нэр дэвшигч оролцохоор тухайн шатны сонгуулийн хороонд бүртгүүлсэн байна.

1.1.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2¹-т заасны дагуу аймгийн Монгол ардын нам, Ардчилсан нам, Наран болон Сүхбаатар сумын ардчилсан намын хороо арилжааны банканд зардлын данс нээлгэсэн талаарх мэдээллийг ирүүлсэн. Харин аймгийн Хөдөлмөрийн үндэсний нам, Иргэний хөдөлгөөний нам дээд шатны намын байгууллагад нэгтгэсэн данс нээлгэсэн талаарх албан бичгийг ирүүлсэн байна.

1.1.3 Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд 611 нэр дэвшигч бүртгүүлснээс 601 нь зардлын данс нээлгэж, төрийн аудитын байгууллагад дансны мэдээллээ ирүүлсэн бол 10 нэр дэвшигч дансны мэдээлэл ирүүлээгүй, арилжааны банканд данс нээлгэсэн эсэх нь тодорхойгүй байна. Энэ нь Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2, 50.3² дахь хэсэгт заасантай нийцэхгүй тул хуульд заасны дагуу эдгээр нэр дэвшигчдийн мэдээллийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу аймгийн Татварын газарт хүргүүллээ.

1.1.4 Аймгийн Монгол Ардын Нам болон Ардчилсан Намд иргэн, хуулийн этгээдээс нийт 68.7 сая төгрөгийн хандив өгснөөс Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасны дагуу нэг сая төгрөгөөс дээш хандив өгсөн иргэн, хоёр сая төгрөгөөс дээш хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээллийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1 Улс төрийн намд хандив өгсөн иргэн хуулийн этгээдийн судалгаа

д/д	Хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийн нэр	Хандивлагчийн регистр, татвар төлөгчийн дугаар	мөнгөн дүн	Хандив авсан намын нэр
1	Б.Оюун-эрдэнэ	220428250515	2,000,000	Ардчилсан нам
2	Д.Болдмаа	220140981995	2,000,000	Монгол ардын нам
3	Ж.Эрдэнэпүрэв	220123450425	2,000,000	Монгол ардын нам
4	Т.Амарбаатар	111941440098	2,000,000	Монгол ардын нам
5	Б.Энхтайван	111928281539	2,000,000	Монгол ардын нам
6	Л.Мөнх-Ундрах	220109670389	2,000,000	Ардчилсан нам
7	Арвижих дарь ХХК	3680789	10,000,000	Монгол ардын нам
8	Сүхбаатар Тээвэр ХХК	3680436	10,000,000	Монгол ардын нам
9	Зотол эрчим ХХК	2742489	10,000,000	Монгол ардын нам
10	Өсөхдэлгэр ХХК	5092981	10,000,000	Ардчилсан нам
11	Өөдлөн тэмүүлэл ХХК	3681939	6,000,000	Ардчилсан нам

¹ Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ.

² Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

12	Жавхлант Сүхбаатар ХХК	3673502	10,000,000	Ардчилсан нам
ДҮН			68,000,000	

(Эх сурвалж: хараат бус аудитын компанийн дүгнэлт)

1.1.5 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвшигчдэд 93.3 сая, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвшигчдэд 111.1 сая төгрөгийн хандивыг иргэн, хуулийн этгээдээс өгсөн байна. Нэр дэвшигчдэд нэг болон хоёр сая төгрөгөөс дээш хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийн нэрийн хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 2 Нэр дэвшигчид иргэн хуулийн этгээдээс өгсөн хандивын судалгаа

№	Нэр дэвшигчийн нэр	Намын харьяалал	Хандивлагчийн нэр	Хандивын эх үүсвэр	Мөнгөн дүн
1	М.Цэцэгмаа	МАН	Э.Гэрэлтцэцэг	бизнесийн орлого	2,000,000.0
2	Г.Алтантуул	МАН	Г.Алтанчимэг	Цалин	1,800,000.0
3	Б.Ганхуяг	МАН	С.Жаргалмаа	Цалин	1,000,000.0
4	А.Түвшинбилэг	МАН	Б.Очирсүх	бизнесийн орлого	2,000,000.0
5	Ё.Самдан	МАН	Б.Дэлхийцэцэг	Тэтгэвэр	1,500,000.0
6	Ц.Сүхбат	МАН	Чинбат	бизнесийн орлого	1,000,000.0
7	Б.Энхтуул	МАН	О.Мөнхжаргал	Цалин	2,000,000.0
8	Г.Баатарсүх	МАН	Өнөрдалай	малын орлого	1,000,000.0
9	А.Түвшинжаргал	АН	Гэрэлтцэцэг	бизнесийн орлого	2,000,000.0
10	Н.Ариунтунгалаг	АН	Д.Баттулга	Цалин	1,283,000.0
11	Н.Ариунтунгалаг	АН	Н.Ариунаа	Тэтгэвэр	1,000,000.0
12	Г.Цэеэмаа	АН	Ө.Золжаргал	Цалин	1,000,000.0
13	Б.Батбал	МАН	О.Болдбаяр	Цалин	1,400,000.0
14	Э.Угтахбаяр	МАН	Мөнхбаяр	Цалин	1,150,000.0
15	Г.Батболд	АН	Т.Ганцэцэг	бизнесийн орлого	1,500,000.0
16	А.Ганхүү	АН	Э.Энхцэцэг	бизнесийн орлого	1,000,000.0
17	О.Нямцэцэг	АН	Б.Баатархүү	Орлого	2,000,000.0
18	А.Адьяасүрэн	АН	Б.Мөнхбаатар	Цалин	1,500,000.0
19	Р.Баярсайхан	ХҮН нам	Г.Мөнх-Эрдэнэ	Цалин	1,000,000.0
20	Б.Отгонбаяр	МАН	Б.Эрдэнэбаяр	бизнесийн орлого	2,000,000.0
21	Э.Ниндэв	МАН	Ц.Доржцэдэв	Цалин	1,000,000.0
22	Э.Ниндэв	МАН	С.Мягмарсүрэн	Цалин	1,000,000.0
23	Э.Ниндэв	МАН	Ц.Гаамаа	Цалин	1,000,000.0
24	Д.Хосбаяр	АН	Ж.Сүхбаяр	бизнесийн орлого	2,000,000.0
25	Д.Хосбаяр	АН	Д.Ууганбор	Цалин	1,000,000.0
26	М.Идэрбат	АН	О.Мөнхмаа	Хуримтлал	2,000,000.0
27	Бям.Батбаатар	АН	У.Болдхүү	бизнесийн орлого	1,000,000.0
28	Б.Батбаатар	АН	Д.Дандий-Ядам	Хадгаламж	1,000,000.0
29	Д.Болд-Эрдэнэ	АН	Ж.Сүхбаяр	бизнесийн орлого	1,000,000.0
30	Бал.Батбаатар	АН	Д.Дандий-Ядам	Хадгаламж	1,000,000.0
31	Г.Ган-Оюу	АН	Н.Мөнх-Эрдэнэ	бизнесийн орлого	1,500,000.0
32	Д.Гантөмөр	АН	Д.Оюунаа	бизнесийн орлого	2,000,000.0
33	А.Нарантуяа	АН	Д.Дандий-Ядам	Хадгаламж	1,000,000.0
34	Б.Ганцогт	АН	Г.Энхбат	бизнесийн орлого	2,000,000.0
35	О.Батсайхан	АН	Д.Дандий-Ядам	Хадгаламж	1,000,000.0
36	Ц.Адьяабаатар	АН	Д.Дандий-Ядам	Хадгаламж	1,000,000.0
37	А.Батдэлгэр	АН	Б.Нямсүрэн	Цалин	2,000,000.0
38	А.Батдэлгэр	АН	Б.Буянхишиг	бизнесийн орлого	2,000,000.0
39	А.Батдэлгэр	АН	Ц.Отгонжаргал	Цалин	2,000,000.0
40	А.Батдэлгэр	АН	Х.Оюунчимэг	анги хамт олон	2,000,000.0

41	И.Батсүх	МАН	Сарантуяа	Тэтгэвэр	2,000,000.0
42	Ц.Мөнхбаатар	МАН	Дарийм	Тэтгэвэр	2,000,000.0
43	Ариунболд	АН	Ганбаатар	цалин	1,000,000.0
44	М.Болормаа	АН	Х.Чинбат	цалин	1,000,000.0
45	О.Мөнхсүлд	МАН	Мөнхсайхан	цалин	1,000,000.0
46	Д.Амарбат	МАН	Дотно финанс ББСБ	бизнесийн орлого	10,000,000.0
47	Т.Мөнхтулга	МАН	Мөнх даатгал	бизнесийн орлого	2,000,000.0
	Нийт дүн				76,633,000.0

(Эх сурвалж: хараат бус аудитын компанийн дүгнэлт)

1.1.6 Нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын дансанд төвлөрсөн мөнгөн хандивыг бүрэн тайлагнаж, хараат бус аудитын компаниар дүгнэлт гаргуулсан байна. Гэвч хуульд заасан мөнгөн бус хандивын талаарх мэдээллийг аудитын дүгнэлтэд тусгаагүй байна.

1.2 Сонгуулийн үйл ажиллагаанд хуулийн шаардлага хангаагүй 11.9 сая төгрөгийн мөнгөн хандив зарцуулсан байна.

1.2.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4³-д шаардлага хангаагүй хандивыг буцаан шилжүүлэхээр зохицуулсан байна.

1.2.2 Сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид эх үүсвэр тодорхойгүй, гүйлгээний утга дутуу 42.4 сая төгрөгийн хандив авч, үүнээс 30.5 сая төгрөгийг хандивлагчдад буцаасан байна.

1.2.3 Харин 50 нэр дэвшигч хуулийн шаардлага хангаагүй 11.9 сая төгрөгийн хандив хүлээн авч, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулжээ. Үүнээс МАН-ын 19 нэр дэвшигч 6.1 сая төгрөг, Ардчилсан намын 30 нэр дэвшигч 5.6 сая төгрөг, ИХН-ын 1 нэр дэвшигч 0.2 сая төгрөгийг буцаан шилжүүлэхгүйгээр зарцуулсан байна.

1.2.4 Хуулийн шаардлага хангаагүй хандивыг буцаан шилжүүлэхгүйгээр сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан нь Сонгуулийн хууль, санхүүжилтийн журам зөрчигдөж, санхүүгийн ил тод байдал алдагдаж, хандивын эх үүсвэрийг зохицуулах боломжгүй болоход хүргэж, хууль бус үйлдэлд оруулах эрсдэлийг үүсгэж байна.

1.2.5 Мөн Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4-д заасны дагуу хууль зөрчин хүлээн авсан хандивыг улсын орлого болгох буюу төрийн санд шилжүүлэх ёстой. Сонгуулийн үйл ажиллагаанд хуульд нийцүүлэн хандив хүлээн аваагүй 50 нэр дэвшигчийн 11.9 сая төгрөгийг төрийн санд төвлөрүүлж, зөрчлийг арилгахыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу аймгийн Татварын газарт шийдвэрлүүлэхээр хүргүүлээ.

БҮЛЭГ2: Нам, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансанд төвлөрсөн хөрөнгийг хуульд нийцүүлэн зарцуулж, зардлын тайлангаа хараат бус аудитын компаниар баталгаажуулсан байна.

³ Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.

2.1 Нэр дэвшигчдийн 97.8 хувь нь сонгуулийн зардлын тайланг хуулийн хугацаанд хүргүүлж дүгнэлт гаргуулжээ.

2.1.1 Аймгийн ИТХ-ын сонгуульд 65, сумын ИТХ-д 546 нэр дэвшигч оролцсон байна. Үүнээс Монгол ардын нам 300, Ардчилсан нам 300, ХҮН нам 3, Иргэний хөдөлгөөний нам 7, бие даагч 1 нэр дэвшигч тус тус аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцжээ.

2.1.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3⁴-т заасны дагуу аймгийн МАН болон Ардчилсан нам 599 нэр дэвшигч сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын тайланд хараат бус аудитын компаниар дүгнэлт гаргуулж, ирүүлсэн. Үүнээс аймгийн ИТХ-ын сонгуульд оролцсон нэр дэвшигчдээс 61 нэр дэвшигч зардлын тайланд дүгнэлт гаргуулсан бол 4 нэр дэвшигч тайлан ирүүлээгүй байна. Зардлын тайлан ирүүлээгүй нэр дэвшигчийг авч үзвэл: Ардчилсан нам 1, ХҮН нам 2, ИХН-ын 1 нэр дэвшигч тус тус зардлын тайлангаа ирүүлээгүй байна.

2.1.3 Сумдын ИТХ-ын ээлжит сонгуульд 546 нэр дэвшигч оролцсоноос 539 нэр дэвшигч зардлын тайлангаа ирүүлсэн бол Ардчилсан нам 1, ИХН-аас тус бүр 2 нэр дэвшигч зардлын тайландаа дүгнэлт гаргуулаагүй байна.

2.1.4 Сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргуулаагүй нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтыг зөрчсөн. Иймд хуулийн 80 дугаар зүйлийн 80.1⁵, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.25⁶, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 1.8.6.20-т заасны дагуу арга хэмжээ авахыг Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчид зөвлөмж болгож, хүргүүллээ.

2.1.5 Сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргуулаагүй нь хуульд заасан шаардлагыг зөрчиж, сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал алдагдах, хандивын эх үүсвэрийг хянах боломжгүй болох, хууль бус санхүүжилт хэрэгжих эрсдэл үүсгэж, сонгуулийн үйл ажиллагааны зохион байгуулалтад сөргөөр нөлөөлөхөөр байна.

2.2 Сонгуулийн зардлын дээд хэмжээг баталсантай холбогдуулан нам, нэр дэвшигчдээс уг зардлыг хэтрүүлэн зарцуулалт хийгдээгүй байна

2.2.1 Улс төрийн намууд сонгуулийн үйл ажиллагаанд нийт 72.4 сая төгрөг зарцуулснаас МАН 38.6 сая (53.2 хувь), Ардчилсан нам 33.8 сая (46.8 хувь) төгрөгийг тус тус зарцуулсан байна. Сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл:

⁴ Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

⁵ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

⁶ Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хүснэгт 3 Улс төрийн намын сонгуульд зарцуулсан мөнгөн хөрөнгө

д/д	Намын нэр	Нийт орлого (сая төг)	үүнээс		Нийт зардал (сая төг)	Үүнээс			Зардлын дансны үлдэгдэл
			өөрийн хөрөнгө	хандив		материал хэвлүүлэх, тараах	үйл ажиллагааны зардал	бусад	
1	Ардчилсан нам	34.0	4.0	30.0	33.8	31.9	0.7	1.2	0.2
2	Монгол Ардын нам	38.7		38.7	38.6	38.6			0.1
	НИЙТ ДҮН	72.7	4.0	68.7	72.4	70.5	0.7	1.2	0.3

2.2.2. Нэр дэвшигчийн зардлын тайлангаас үзэхэд аймгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн зардлын дансанд 140.8 сая төгрөг төвлөрснөөс өөрийн хөрөнгө 66.5 сая (47.2 хувь), хандив тусламжийн орлого 74.3 сая (52.8 хувь) төгрөг тус тус эзэлж байна. Сонгуулийн зардлын дансанд төвлөрсөн мөнгөн хөрөнгөнөөс 140.5 сая төгрөгийг зарцуулж, 0.3 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна. Гэвч сонгуулийн дансны үлдэгдлийг хэрхэн зохицуулах талаар хууль, тогтоомжид тодорхой заалт тусгаагүй байна. Аймгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчид 0.1-10.3 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2.2.3 Нэр дэвшигчийн сонгуулийн үйл ажиллагааны зардлыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл:

- Сурталчилгааны материал хэвлүүлэх, тараах зардалд 30.4 сая;
- Ухуулагчийн ажлын хөлс, урамшуулалд 60.1 сая;
- Тээврийн хэрэгслийн зардалд 31.1 сая;
- Сонгогчтой уулзалт зохион байгуулах, ухуулах байр түрээслэхэд 9.4 сая;
- Бусад зардалд 9.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Сумын ИТХ-ын сонгуульд оролцсон 249 нэр дэвшигч (МАН 118, АН 130, ИХН 1) буюу нийт нэр дэвшигчийн 45.6 хувь нь сонгуулийн үйл ажиллагаанд мөнгөн хөрөнгө зарцуулаагүй (Х тайлан ирүүлсэн) гэж тайлагнажээ.

Харин 292 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд 190.2 сая төгрөг зарцуулснаас өөрийн хөрөнгөнөөс 85.6 сая, хандиваар 104.6 сая төгрөгийг бүрдүүлж, 187.1 сая төгрөгийг зарцуулж 3.1 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 4. Сумын ИТХ-д нэр дэвшигчийн зарцуулсан зардлын задаргаа

д/д	Зардлын төрөл	Мөнгөн дүн	эзлэх хувь
1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал	12.7	6.6

2	Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал	136.0	72.7
3	Нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал	32.2	17.6
4	Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал	4.3	2.2
5	Бусад зардалд	1.9	0.9
НИЙТ		187.1	100

Нэр дэвшигчийн сонгуульд зарцуулсан нийт зардлын 72.7 хувь буюу 140.1 сая төгрөгийг ухуулагчийн ажлын хөлс, урамшуулалд зарцуулсан байна. Сонгуульд зарцуулсан зардлыг 2020 оны ээлжит сонгуулийн зардалтай харьцуулж үзэхэд 11.3 сая төгрөгөөр бага мөнгөн хөрөнгийг зарцуулсан байна.

Нам, нэр дэвшигчээс сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн хөрөнгө нь Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны А/66, А/67 тоот тушаалаар баталсан зардлын дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

-----ooOoo-----

ДҮГНЭЛТ:

Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн 97.8 хувь буюу 604 нэр дэвшигч зардлын тайландаа хараат бус аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж, ирүүлсэн байна.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвшигчдэд 204.4 сая төгрөг, улс төрийн намд 68.7 сая төгрөгийн хандивыг иргэн, хуулийн этгээдээс өгсөн байна.

Хуулийн шаардлага хангаагүй 11.9 сая төгрөгийн хандивыг хүлээн авч, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Нам, нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн хөрөнгө нь Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны А/66, А/67 тушаалаар баталсан зардлын дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Санхүү Төрийн Сангийн Хэлтэст:

- Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн Хавсралт 1-д заасан нэр дэвшигчдэд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах.

Аймгийн татварын хэлтэст:

- Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн Хавсралт 1-д заасан нэр дэвшигчдэд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21, 23, 24-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах.